

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 12 дугаар сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2011-11 сар	/тоогоор/		
			Нэмэгдсэн	Хасагдсан	2011-12 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	166	11 <sup>1</sup>		177
3	Даатгалын төлөөлөгч	2118		89 <sup>2</sup>	2029
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	9			9
6	Актуарч	13			13
7	Бусад	1	10 <sup>3</sup>		10

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын компанийн салбарын тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны даргын 2011 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 дүгээр тушаалаар “Мөнх даатгал” ХХК-д Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд, мөн өдрийн 200 дугаар тушаалаар “Ард даатгал” ХХК-д Баян-Өлгий аймгийн Өлгий сум, Булган аймгийн Булган сум, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум, Дорноговь аймгийн Сайншанд сум, Ховд аймгийн Жаргалант суманд болон Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт тус тус даатгалын салбар нээн ажилуулахыг зөвшөөрсөн байна.

<sup>2</sup> Хорооны даргын 2011 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 201 дүгээр тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгч П. Гаравмаа, Хорооны даргын 2011 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 228 дугаар тогтоолоор “Бодь даатгал” ХХК-ийн нийт 86 иргэн, Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 396 дугаар тогтоолоор “Бодь даатгал” ХХК-ийн Орхон аймаг дахь даатгалын төлөөлөгч Ц. Дэмчигжав, Увс аймаг дахь даатгалын төлөөлөгч Б. Балдорж, нарын даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгох шийдвэрүүд гарсан байна.

<sup>3</sup>Хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 342 дугаар тогтоолоор “Мөнх даатгал” ХХК, 343 дүгээр тогтоолоор “Номин даатгал” ХХК, 344 дүгээр тогтоолоор “Миг даатгал” ХХК, Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 388 дугаар тогтоолоор “Соёмбо даатгал” ХХК, 389 дугаар тогтоолоор “Ард даатгал” ХХК, 390 дүгээр тогтоолоор “Монгол даатгал” ХХК, 391 дүгээр тогтоолоор “Моннис даатгал” ХХК, 392 дугаар тогтоолоор “Тэнгэр даатгал” ХХК, 393 дугаар тогтоолоор “Бодь даатгал” ХХК, 394 дүгээр тогтоолоор “Монре даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Мөн Хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 349 дүгээр тогтоолоор “Мега марз” ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг сэргээсэн байна.

## 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 12 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 12 дугаар сарынхтай харьцуулбал:

### Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-ХII	2011-ХII
1	Даатгалын нийт хураамж	2 774 431 724.1	5 376 450 007.33
2	Олгосон нийт нөхөн төлбөр	621 998 165.8	1 154 531 811.87
3	Давхар даатгалд төлсөн хураамж	284 598 113.4	472 464 212.14
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	10143	12428
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	12 773 000 000.0	25 000 000 000
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	51 824 400.0	54 062 051.94

2011 оны 12 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 2602.2 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 532.6 сая төгрөгөөр, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 187.9 сая төгрөгөөр тус тус өсчээ.

2011 оны 12 дугаар сард “Гэр даатгал” ХХК шинээр даатгалын гэрээ байгуулаагүй, даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөхөн төлбөргүй ажилласан байна.

Ердийн даатгалын компаниудын 2011 оны 12 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Бодь даатгал” ХХК-ийн 25.0 тэрбум төгрөгийн үнэлгээтэй даатгалын гэрээ байсан бол хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр болох 54.0 сая төгрөгийг “Тэнгэр даатгал” ХХК олгосон байна.

### Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	2010-ХII	2011-ХII
1	Даатгалын нийт хураамж	16 640 138.1	19 141 441.55
2	Олгосон нийт нөхөн төлбөр	5 145 485.0	10 997 262.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	1 117 431.74
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	17	11

	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	3	4
	-Байгууллагын хугацаат даатгалд	2	2
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	-	-
	- Эмнэлгийн мөнгөний даатгалд	-	-
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	9	
	-Тэтгэврийн даатгалд	2	2
	-Орон сууцны даатгалд	1	
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	24 000 000.0	50 000 000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	469 040.0	2 000 000.0

Урт хугацааны даатгалын компанийн 2011 оны 12 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны 12 дугаар сартай харьцуулбал даатгалын хураамжийн орлого 2.5 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 5.8 сая төгрөгөөр, давхар даатгалын хураамж 1.1 сая төгрөгөөр тус тус өсч, хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ нь 50.0 сая төгрөг, хамгийн их нөхөн төлбөр 2.0 сая төгрөг байсан байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-11 сар	2011-12 сар	Өсөлт бууралт
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	88 316 260.12	51 500 352.03	-36 815 908
2	Даатгалын зуучлагчийн орлого	28 347 990.37	48 221 095.87	19 873 105
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	-	60	60
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3 530 345 878.00	24 416 916 104	20 886 570 226

2011 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 51.5 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр дүнтэй 344.4 сая төгрөгийн үнэлгээтэй 34.6 сая төгрөгийн гэрээг “Ачит ундарга” ХХК зуучлан борлуулсан байна.

Тайлант хугацаанд “Монголиан интернэшнл брокерс” ХХК даатгалын зуучлалын орлогогүй ажилласан байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	2011-11 сар	2011- 12 сар	Өөрчлөлт
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	7 631 900.00	8 695 360.00	1 063 460
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	334	398	64
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	73 383 000.00	25 996 529	-47 386 471

2011 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 398 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж 8.7 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК, “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК даатгалын хохирол үнэлсэн орлогогүй байна.

### 3. БУСАД

Хорооны 2011 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 345 дугаар тогтоолоор “Миг даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай, Хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 346 дугаар тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрөх тухай, 347 дугаар тогтоолоор “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай, 348 дугаар тогтоолоор “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай, 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 395 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам” батлах тухай, 398 дугаар тогтоолоор “Монгол даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэхийг зөвшөөрөх тухай, 399 дүгээр тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирлыг томилох тухай шийдвэрүүдийг гаргасан байна.